



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/101/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: munkhatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор:      Б.Азбаяр Утас: 99061429      Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	---

## Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/ .....	2021.12.31 ... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/ .....	2021.12.31 ... 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/ .....	2021.12.31... 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31 .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ .....	2021.12.31 ... 9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ .....	2021.12.31 .. 10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.16 № 2115

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\alban bichig\A4-toot.docx

005020214

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ



**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/**

2021.12.31

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>97,339,295.48</b>	<b>123,108,552.38</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>11,049,826.00</b>	<b>10,749,826.00</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>11,049,826.00</b>	<b>10,749,826.00</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>11,049,826.00</b>	<b>10,749,826.00</b>
31211	Төрийн сангийн харилцах	11,049,826.00	10,749,826.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>86,289,469.48</b>	<b>112,358,726.38</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>23,544,888.99</b>	<b>32,327,326.27</b>
35110	Тусгай зориулалттай материал	9,807,810.17	10,261,904.48
35130	Эм боох материал	13,737,078.82	22,065,421.79
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>62,744,580.49</b>	<b>80,031,400.11</b>
35410	Бичиг хэргийн материал	6,216,978.89	8,033,578.89
35420	Аж ахуйн материал	24,293,257.00	31,035,457.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,750,000.00	1,308,150.00
35440	Түлш, шатах тослох материал	3,135,709.20	2,375,161.20
35470	Бусад хангамжийн материал	26,348,635.40	37,279,053.02
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,468,241,005.58</b>	<b>1,401,822,436.24</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,468,241,005.58</b>	<b>1,401,822,436.24</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,390,507,728.09</b>	<b>1,326,118,525.90</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,296,852,003.00	1,296,852,003.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-62,390,162.86	-93,542,569.76
39203	Авто-тээврийн хэрэгсэл	78,538,000.00	78,538,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-30,028,542.62	-38,701,943.50
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	289,430,052.00	296,802,772.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-203,764,590.67	-230,304,080.51
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,333,579.00	35,834,399.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-30,137,043.72	-30,701,758.69
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,803,200.00	14,803,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,128,766.04	-3,461,495.64
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>77,733,277.49</b>	<b>75,703,910.34</b>
39301	Програм хангамж	1,262,200.00	1,262,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,187,794.38	-1,213,318.83
39303	Бусад биет бус хөрөнгө	82,845,000.00	82,845,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-5,186,128.13	-7,189,970.83
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,565,580,301.06</b>	<b>1,524,930,988.62</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,565,580,301.06</b>	<b>1,524,930,988.62</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,565,580,301.06</b>	<b>1,524,930,988.62</b>
<b>511</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	<b>1,087,914,987.82</b>	<b>1,087,914,987.82</b>
51101	Өмч: - төрийн	1,087,914,987.82	1,087,914,987.82
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-4,827,573.17</b>	<b>-45,100,585.61</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-4,827,573.17	-4,451,273.17
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-40,649,312.44
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	482,492,886.41	482,116,586.41
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,565,580,301.06</b>	<b>1,524,930,988.62</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/**

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>948,773,955.64</b>	<b>824,765,304.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>82,172,355.64</b>	<b>31,833,804.50</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>82,172,355.64</b>	<b>31,833,804.50</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	77,205,755.64	27,833,804.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,859,100.00	21,458,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	413,291.19	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	60,933,364.45	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	0.00	90,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	0.00	6,285,804.50
120009	Бусад орлого	4,966,600.00	4,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>866,601,600.00</b>	<b>792,931,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>851,801,600.00</b>	<b>791,948,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	851,801,600.00	791,948,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>14,800,000.00</b>	<b>983,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,800,000.00	878,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	105,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>888,984,580.62</b>	<b>865,414,616.94</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>888,984,580.62</b>	<b>865,414,616.94</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>794,002,314.64</b>	<b>813,269,325.33</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>496,776,913.41</b>	<b>493,283,695.32</b>
210101	Үндсэн цалин	467,815,961.41	349,581,124.32
210102	Нэмэгдэл	1,700,000.00	118,565,173.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,866,800.00	15,918,500.00
210104	Урамшуулал	11,394,152.00	9,218,898.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>60,587,479.80</b>	<b>62,684,354.07</b>
210201	Тэтгэврийн даатгал	41,911,473.80	44,272,253.47
210202	Тэтгэмжийн даатгал	4,930,759.30	4,919,960.64
210203	ҮОМШ өвчний даатгал	3,934,527.30	3,941,033.48
210204	Ажилгүйдлын даатгал	891,882.40	868,282.61
210205	Эрүүл мэндийн даатгал	8,918,837.00	8,682,823.87
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>59,523,345.00</b>	<b>61,071,167.00</b>
210301	Гэрэл цахилгаан	3,431,610.00	2,985,295.00
210302	Түлш, халаалт	47,751,855.00	50,935,312.00
210303	Цэвэр, бохир ус	8,339,880.00	7,150,560.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>40,883,387.58</b>	<b>33,483,215.78</b>
210401	Бичиг хэрэг	6,732,193.18	7,041,440.00
210402	Тээвэр, шатахуун	16,978,644.00	18,275,803.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	6,107,615.00	6,057,252.00
210404	Ном, хэвлэл	15,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	225,000.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,241,330.56	1,280,825.00
210408	Бараа материал акалсны зардал	9,583,604.84	327,895.78
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>5,450,430.79</b>	<b>8,204,066.94</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,200,430.79	3,576,066.94

**Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210502	Хоол, Хүнс	2,250,000.00	4,628,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>22,257,501.60</b>	<b>34,755,576.88</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	5,482,190.60	14,662,626.88
210604	Урсгал засвар	16,775,311.00	20,092,950.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>23,077,300.00</b>	<b>20,596,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	23,077,300.00	20,596,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,726,516.00</b>	<b>16,450,660.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,940,300.00	11,047,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,136,900.00	2,136,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,551,700.00	2,551,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	315,116.00	163,460.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	396,000.00	198,000.00
210807	Газрын төлбөр	298,500.00	298,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>71,719,440.46</b>	<b>82,739,789.34</b>
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	997,500.00	1,006,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	70,721,940.46	81,733,189.34
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>94,982,265.98</b>	<b>52,145,291.61</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>77,808,500.00</b>	<b>24,440,380.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,800,000.00	4,300,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	64,208,500.00	17,290,380.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,800,000.00	2,850,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>17,173,765.98</b>	<b>27,704,911.61</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,314,665.98	6,830,411.61
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэн шилжүүлэг	15,824,100.00	20,874,500.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	35,000.00	0.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>59,789,375.02</b>	<b>-40,649,312.44</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/**

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>0</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>887,427,300.00</b>	<b>818,389,500.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>20,825,700.00</b>	<b>25,458,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>20,825,700.00</b>	<b>25,458,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,859,100.00	21,458,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,859,100.00	21,458,000.00
120009	Бусад орлого	4,966,600.00	4,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>866,601,600.00</b>	<b>792,931,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>851,801,600.00</b>	<b>791,948,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	851,801,600.00	791,948,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>14,800,000.00</b>	<b>983,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,800,000.00	878,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	105,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>851,465,700.00</b>	<b>803,464,880.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>851,465,700.00</b>	<b>803,464,880.00</b>

**Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	756,483,434.02	751,319,588.39
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	496,363,622.22	493,283,695.32
210101	Үндсэн цалин	357,476,527.22	349,581,124.32
210102	Нэмэгдэл	111,626,143.00	118,565,173.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	15,866,800.00	15,918,500.00
210104	Урамшуулал	11,394,152.00	9,218,898.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	60,587,479.80	62,684,354.07
210201	Тэтгэврийн даатгал	41,911,473.80	44,272,253.47
210202	Тэтгэмжийн даатгал	4,930,759.30	4,919,960.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,934,527.30	3,941,033.93
210204	Ажилгүйдлийн даатгал	891,882.40	868,282.61
210205	Эрүүл мэндийн даатгал	8,918,837.00	8,682,823.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	59,523,345.00	61,071,167.00
210301	Гэрэл, цахилгаан	3,431,610.00	2,985,295.00
210302	Түлш, халаалт	47,751,855.00	50,935,312.00
210303	Цэвэр, бохир ус	8,339,880.00	7,150,560.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	31,566,191.00	32,507,472.00
210401	Бичиг хэрэг	7,600,200.00	7,173,400.00
210402	Тээвэр, шатахуун	14,617,800.00	16,852,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,107,615.00	6,057,252.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	225,000.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,576.00	1,924,420.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	15,321,600.00	17,839,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,538,600.00	12,686,400.00
210502	Хоол, хүнс	2,250,000.00	4,628,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	533,000.00	525,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	54,015,880.00	44,285,440.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	34,415,569.00	25,634,340.00
210604	Урсгал засвар	19,600,311.00	18,651,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	23,077,300.00	20,596,800.00
210702	Дотоод албан томилолт	23,077,300.00	20,596,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	15,030,516.00	18,044,660.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,940,300.00	11,047,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,136,900.00	2,136,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,551,700.00	2,551,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	315,116.00	163,460.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,386,000.00	1,503,000.00
210807	Газрын төлбөр	298,500.00	298,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	314,000.00	289,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	997,500.00	1,006,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	997,500.00	1,006,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	94,982,265.98	52,145,291.61
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	77,808,500.00	24,440,380.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,800,000.00	4,300,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	64,208,500.00	17,290,380.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,800,000.00	2,850,000.00

**Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,173,765.98	27,704,911.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,314,665.98	6,830,411.61
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэн шилжүүлэг	15,824,100.00	20,874,500.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	35,961,600.00	14,924,620.00
0	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	32,887,500.00	15,224,620.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	32,887,500.00	15,224,620.00
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	32,887,500.00	15,224,620.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	32,887,500.00	15,224,620.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	-32,887,500.00	-15,224,620.00
0	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН</b>		
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	3,074,100.00	-300,000.00
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	7,975,726.00	11,049,826.00
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	11,049,826.00	10,749,826.00

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,087,914,987.82	482,550,590.41	-64,674,652.19	0.00	1,505,790,926.04
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,087,914,987.82	482,550,590.41	-64,674,652.19	0.00	1,505,790,926.04
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	57,704.00	-57,704.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	59,789,375.02	0.00	59,789,375.02
C08	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,087,914,987.82	482,492,886.41	-4,827,573.17	0.00	1,565,580,301.06
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,087,914,987.82	482,492,886.41	-4,827,573.17	0.00	1,565,580,301.06
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,087,914,987.82	482,492,886.41	-4,827,573.17	0.00	1,565,580,301.06
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	376,300.00	-376,300.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн	0.00	0.00	0.00	0.00	0.00

**Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

	зөвшөөрөөгүй олз, гарз					
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-40,649,312.44	0.00	-40,649,312.44
D09	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,087,914,987.82	482,116,586.41	-45,100,585.61	0.00	1,524,930,988.62

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/**

2021.12.31

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>11,049,826.00</b>		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>791,948,500.00</b>	<b>790,001,588.39</b>	(1,946,911.61)	99.8
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>791,948,500.00</b>	<b>790,001,588.39</b>	(1,946,911.61)	99.8
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>771,181,800.00</b>	<b>765,561,208.39</b>	(5,620,591.61)	99.3
2101	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>493,837,900.00</b>	<b>493,283,695.32</b>	(554,204.68)	99.9
210101	Үндсэн цалин	349,583,500.00	349,581,124.32	(2,375.68)	100.0
210102	Нэмэгдэл	118,586,400.00	118,565,173.00	(21,227.00)	100.0
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	15,928,000.00	15,918,500.00	(9,500.00)	99.9
210104	Урамшуулал	9,740,000.00	9,218,898.00	(521,102.00)	94.6
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>66,668,200.00</b>	<b>62,684,354.07</b>	(3,983,845.93)	94.0
210201	Тэтгэврийн даатгал	46,914,600.00	44,272,253.47	(2,642,346.53)	94.4
210202	Тэтгэмжийн даатгал	4,938,400.00	4,919,960.64	(18,439.36)	99.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,950,700.00	3,941,033.93	(9,666.07)	99.8
210204	Ажилгүйдлийн даатгал	987,700.00	868,282.61	(119,417.39)	87.9
210205	Эрүүл мэндийн даатгал	9,876,800.00	8,682,823.42	(1,193,976.58)	87.9
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>61,705,600.00</b>	<b>61,071,167.00</b>	(634,433.00)	99.0
210301	Гэрэл, цахилгаан	3,447,500.00	2,985,295.00	(462,205.00)	86.6
210302	Түлш, халаалт	51,080,900.00	50,935,312.00	(145,588.00)	99.7
210303	Цэвэр, бохир ус	7,177,200.00	7,150,560.00	(26,640.00)	99.6
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>32,227,100.00</b>	<b>31,934,272.00</b>	(292,828.00)	99.1
210401	Бичиг хэрэг	7,100,200.00	7,100,200.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	16,352,400.00	16,352,400.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,273,800.00	6,057,252.00	(216,548.00)	96.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	500,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,700.00	1,924,420.00	(76,280.00)	96.2
2105	<b>Нормативт зардал</b>	<b>17,469,400.00</b>	<b>17,461,400.00</b>	(8,000.00)	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,686,400.00	12,686,400.00	-	100.0
210502	Хоол, хүнс	4,250,000.00	4,250,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	533,000.00	525,000.00	(8,000.00)	98.5
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>59,434,100.00</b>	<b>59,510,060.00</b>	75,960.00	100.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,148,400.00	15,224,620.00	76,220.00	100.5
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	25,634,600.00	25,634,340.00	(260.00)	100.0

**Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210604	Урсгал засвар	18,651,100.00	18,651,100.00	-	100.0
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>20,596,800.00</b>	<b>20,596,800.00</b>	-	100.0
210702	Дотоод албан томилолт	20,596,800.00	20,596,800.00	-	100.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>18,235,200.00</b>	<b>18,012,860.00</b>	(222,340.00)	98.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,017,100.00	11,015,300.00	(1,800.00)	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,136,900.00	2,136,900.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	2,551,700.00	2,551,700.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	315,200.00	163,460.00	(151,740.00)	51.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	55,000.00	(33,000.00)	62.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,527,000.00	1,503,000.00	(24,000.00)	98.4
210807	Газрын төлбөр	298,500.00	298,500.00	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	300,800.00	289,000.00	(11,800.00)	96.1
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,007,500.00</b>	<b>1,006,600.00</b>	(900.00)	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	1,007,500.00	1,006,600.00	(900.00)	99.9
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>20,766,700.00</b>	<b>24,440,380.00</b>	3,673,680.00	117.7
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>20,766,700.00</b>	<b>24,440,380.00</b>	3,673,680.00	117.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,866,700.00	17,290,380.00	(576,320.00)	96.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,900,000.00	2,850,000.00	(50,000.00)	98.3
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>791,948,500.00</b>	<b>790,001,588.39</b>	(1,946,911.61)	99.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	791,948,500.00	790,001,588.39	(1,946,911.61)	99.8

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>14,800,000.00</b>	<b>983,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>14,800,000.00</b>	<b>983,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>14,800,000.00</b>	<b>983,000.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>0.00</b>	<b>573,200.00</b>
210401	Бичиг хэрэг	0.00	73,200.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	500,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>0.00</b>	<b>378,000.00</b>
210502	Хоол, хүнс	0.00	378,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,800,000.00</b>	<b>31,800.00</b>
<b>210801</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>14,800,000.00</b>	<b>31,800.00</b>
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>14,800,000.00</b>	<b>983,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>14,800,000.00</b>	<b>983,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,800,000.00	878,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,800,000.00	105,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын нутаг дэвсгэрт хуулийг сахиулан, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх, хүний болон нийгмийн тогтвортой хөгжил, бизнес эрхлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд хяналт шалгалт хийх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

МХЕГ нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 888,984.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,889.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,222.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 6,057.9 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,649.3 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	97,339.3	123,108.6	25,769.3
Мөнгөн хөрөнгө	11,049.8	10,749.8	(300.0)
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	86,289.5	112,358.7	26,069.3
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,468,241.0	1,401,822.4	(66,418.6)
Үндсэн хөрөнгө	1,802,064.0	1,806,937.6	4,873.5
Хуримтлагдсан элэгдэл	(333,823.0)	(405,115.1)	(71,292.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,565,580.3</b>	<b>1,524,931.0</b>	<b>(40,649.3)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,565,580.3	1,524,931.0	(40,649.3)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,565,580.3</b>	<b>1,524,931.0</b>	<b>(40,649.3)</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 10,749.8 мянган төгрөг болж 300.0 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн дансанд 4,000.0 мянган төгрөг төвлөрүүлж, 4,300.0 мянган төгрөг зарцуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 112,358.7 мянган төгрөг болж 26,069.3 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал дансны үлдэгдэл өмнөх оноос 8,328.3 мянга, Аж ахуйн материал 6,742.2 мянга, Бусад хангамжийн материал 10,930.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,806,934.6 мянган төгрөг болж 4,873.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 15,224.6 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан бол 10,441.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил акталсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,524,931.0 мянган төгрөг болж 40,649.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 40,649.3 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 959,256.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 959,256.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 177,920.3 мянган төгрөгөөр бууруулж 781,336.0 мянган төгрөгөөр анх батлагдсан бөгөөд гол бууруулсан зардал нь цалингийн зардал 154,061.8 мянга, ЭМНДШ 18,233.8 мянган төгрөг голлох дүнг эзэлж байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 791,948.5 мянган төгрөгийн төсөв баталсныг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 791,948.5 мянган төгрөгийн санхүүжилт урсгал үйл ажиллагаанд 785,701.6 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 6,246.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 785,701.6 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа цалин хөлс нэмэгдэл урамшил 554.2, ажил олгогчоос олгох НДШ 3,983.8, байр ашиглалттай холбоотой зардал 634.4, хангамж материалын зардал 216.5, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 222.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна. Цалин, ЭМНДШ хэмнэгдсэн нь 2 орон тоо дутуу ажилласантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас дархлаажуулалтын хяналтын зардал 878.0 мянган төгрөг олгосныг бүрэн зарцуулсан бөгөөд цахим тендерийн орлогоор 105.0 мянган төгрөг орсныг үнэлгээний хорооны үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Амаржаргал санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг МХЕГ-аас дүгнэж ирүүлээгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 865,414.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 23570.0 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон тэтгэмжийн зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол бусад зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 907,215.5 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 147 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	0
3	Улирал бүр	1	4	4	0	0
4	Сар бүр	3	36	36	0	0
5	Тухай бүр	8	96	94	2	0
6	Нийт	27	151	147	2	2

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол нь тусгай чиг үүргийн байгууллагад хамаарахгүй гэж заасан байна. Тайлант оны эцэст 6,246.9 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4500,0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

### 4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1.1. Илрүүлэлт:

Эд хогшлын зардлаас 2021 оны 11 дүгээр сарын 10-нд цахим хурлын тоног, төхөөрөмж авахаар 4,500.0 мянган төгрөгийг шилжүүлж, оны эцэст хөрөнгө ирээгүй байхад хөрөнгийг орлогод авсан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.26-д заасан “Бэлтгэн нийлүүлэгчид бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг урьдчилж төлсөн урьдчилгаа болон урьдчилан төлсөн зардлуудыг урьдчилж төлсөн төлбөр /зардал/ гэнэ.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Тухайн цахим төхөөрөмжийг аудит хийгдэх үеэр хүлээн авсан тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн болно.

#### 1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид бэлтгэн нийлүүлэгчээс гэрээгээр хөрөнгө худалдан авахаар гэрээ хийж урьдчилгаа төлбөр өгсөн тохиолдолд урьдчилгаа төлбөрөөр бүртгэж 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг мөрдөж ажиллах.

#### 2.1. Илрүүлэлт:

Шилэн дансны цахим сайтад нийт 149 мэдээ байршуулахаас 2 мэдээг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-т заасан “Энэ хуулийн 3.1.1,

3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

**2.2. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн 6.4-т заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж ажиллах.

**3.1. Илрүүлэлт:**

Лабораторийн шинжилгээний төлбөрийг дүгнэлт, шинжилгээ авахаас өмнө дансанд тушаалгаж орлогыг дансанд орсон дүнгээр бүртгэж байгаа боловч шинжилгээ хийсэн тоо, батлагдсан тарифаар тооцож хяналт хийгээгүй байгаагаас үзэхэд нягтлан бодогч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д заасан “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн үүргийг хэрэгжүүлээгүй байна.

**3.2. Өгсөн зөвлөмж:**

Тайлант оны шинжилгээ хийсэн статистик мэдээг нөхөн гаргуулан авч тооцоог бодож, үр дүнг ирүүлэх, цаашид урвалж бодис, шинжилгээ хийсэн тоог авч үзэн орлого бүрэн төвлөрч байгаа эсэх талаар хяналт тавьж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймгийн МХГ	2	4500.0	0	0	0	0	0	0	2	4500.0

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_